

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

АУДИТЫН КОД: ХӨА-2026/02-21/СТА-НА-НТГ

Цахим хуудас: www.audit.mn

Дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар Утас:88883317
Цахим хаяг: Erdnebaatara@audit.gov.mn
Аудитын менежер Б.Тэгшдэлгэр Утас: 99089114
Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn
Ахлах аудитор Г.Ичинхорлоо Утас: 88012671
Цахим хаяг: ichinkhorlooga@audit.gov.mn
Аудитор С.Гансүх Утас: 99669006
Цахим хаяг: gansukhsa@audit.gov.mn
Аудитор Л.Мөнх-Оргил Утас: 99039344
Цахим хаяг: munkh-orgill@audit.gov.mn
Аудитор Х.Энхтуяа Утас: 89182456

Цахим хаяг: enkhtuyakh@audit.gov.mn

**Мөрөн сум
2026 он**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/12

Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2025 оны А/86 дугаар тушаал, "Эрх үүрэг шилжүүлэх тухай" 2023 оны А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх заалт, 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 3.4.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөвсгөл аймгийн Засаг даргын 2025 оны жилийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газар, Хөвсгөл аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

3. Аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг 2026 оны 12 дугаар сарын 10-ний дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Л.Төмөрбаатар/-д зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор /Г.Ичинхорлоо/-д үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер /Б.Тэгшдэлгэр/-д даалгасугай.



А.ЭРДЭНЭБААТАР

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ:

Хөвсгөл аймгийн орон нутгийн 2025 оны төсвийн төслийг боловсруулахдаа Сангийн яамны 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”, Сангийн яамнаас ирүүлсэн төсвийн хязгаар, төсвийн удирдамж, Төсвийн тухай хууль, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмыг баримтлан ажилласан байна. Аймгийн төсвийн суурь орлого зардлын хязгаарыг төлөвлөж баталсан байдлыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №-1. Төсвийн суурь орлого зардлын хязгаарыг төлөвлөж баталсан байдал

№	Үзүүлэлт	МУЗГ-ын 2024.7.24- ны 10 дугаар тогтоол	Хөвсгөл аймгийн төсвийн төсөл	Зөрүү
1	Суурь орлого	39,531.1	42,661.4	3,130.0
2	Суурь зардал	83,383.9	80,918.2	-2,465.7

Монгол улсын Засгийн газрын 2024 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 10 дугаар тогтоолоор Хөвсгөл аймгийн 2025 оны төсвийн суурь орлогын доод хязгаарыг 39,531.1 сая төгрөг, суурь зардлын хязгаарыг 83,383.9 сая төгрөгөөр тус тус тогтоосон байна.

Хөвсгөл аймгийн 2025 оны төсвийн төсөлд суурь орлогыг Засгийн газрын баталснаас 3,130.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 42,661.4 сая төгрөг, суурь зардлыг 2,465.7 сая төгрөгөөр бууруулж 80,918.2 сая төгрөгөөр тус тус төлөвлөсөн байна.

Хөвсгөл аймгийн 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөллийг нэгтгэн боловсруулж Хөвсгөл аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 1/1362 дугаартай албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн байна.

Хөвсгөл аймгийн 2025 оны орон нутгийн төсвийн орлого, зарлагыг 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны III/31 дүгээр тогтоолоор Хөвсгөл аймгийн төсвийг анх 141,868.4 сая төгрөгөөр баталсан байна.

Улсын төсөвт тодотгол хийснээр аймгийн ИТХ-ын хуралдааны 2025 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 74 дүгээр тогтоолоор 2025 оны орон нутгийн төсөвт тодотгол хийж 4,615.5 сая төгрөгөөр төсвийг бууруулж 137,252.9 сая төгрөгөөр баталсан байна.

Хөвсгөл аймгийн Засаг даргын захирамжаар харьяа байгууллагуудын төсөвт нийт 2 удаагийн зохицуулалт хийсэн байна.

БҮЛЭГ 1: ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ 4,615.5 САЯ ТӨГРӨГИЙН ХАСАХ ТОДОТГОЛЫГ ХИЙСЭН БА ҮҮНИЙ 75.9 ХУВЬ НЬ БАЙР АШИГЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ЗАРДЛЫГ БУУРУУЛСАН БАЙНА.

1.1 Орон нутгийн төсвийн орлогын саналыг өмнөх оны орлогын гүйцэтгэлээс 31,794.6 сая төгрөг буюу 53.3 хувиар бууруулж боловсруулж хүргүүлсэн байна.

1.1.1 Хөвсгөл аймгийн 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөллийг нэгтгэн боловсруулж Хөвсгөл аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 1/1362 дугаартай албан бичгээр орон нутгийн орлогоос 27,842.2 сая төгрөгийг бүрдүүлэхээр тооцож Сангийн яаманд төсвийн санал хүргүүлсэн байна. Үүнд:

- Татварын орлогыг 27,150.6 сая төгрөгөөр
- Татварын бус орлогыг 671.5 сая төгрөгөөр
- Хөрөнгийн орлогыг 20.1 сая төгрөгөөр тооцож төлөвлөсөн байна.

Сангийн яам орон нутгийн төсвийн суурь орлогыг 8,346.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт 36,188.6 сая төгрөгөөр хянаж, аймгийн ИТХ-аар 42,850.0 сая төгрөгөөр баталсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №-2. Суурь орлогын төсөв		/сая.төг/	
Орлогын нэр төрөл	2024 он	2025 он	

	Гүйцэтгэл	СЯ-нд хүргүүлсэн дүн	СЯ-ны хянасан дүн	ИТХ-аас анх баталсан дүн	Зөрүү
	1	2	3	4	5=1-2
1.Татварын орлого	56,571.2	27,150.6	35,482.0	41,617.4	29,420.6
2.Татварын бус орлого	2,962.8	671.5	686.5	1,213.5	2,291.3
3.Хөрөнгийн орлого	102.8	20.1	20.1	19.1	82.7
Нийт орлого	59,636.8	27,842.2	36,188.6	42,850.0	31,794.6

Дээрх хүснэгтээс харахад орон нутгаас Сангийн яаманд хүргүүлсэн суурь орлогын төсвийн төслийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 31,794.6 сая төгрөг буюу 53.3 хувиар бууруулж боловсруулж хүргүүлсэн, Сангийн яамны хянасан дүнг 6,661.4 сая төгрөгөөр нэмж 42,850.0 сая төгрөгөөр орон нутгийн орлогыг баталсан байна. Энэ байдлаас харахад орон нутгийн орлогын төсвийн санал боловсруулахдаа өмнөх оны гүйцэтгэл, татварын болон бусад эх үүсвэрээс орох орлогыг бүрэн тооцож төлөвлөхгүй байгааг харуулж байна.

1.1.2 Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дахь заалтад заасны дагуу улсын төсөвт 11,159.5 сая төгрөгийн 8 нэр төрлийн орлогыг төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт №-3. Улсын төсөвт төвлөрүүлэх орлого.

/сая.төг/				
№	Татварын төрөл	Өмнөх оны гүйцэтгэл	Төлөвлөгөө	Зөрүү
1	ААНОАТ	2,353.4	2,600.0	246.6
2	Суутгасан ААНОАТ	15.4	-	-15.4
3	НӨАТ	7,158.0	8,000.0	842.0
4	Онцгой албан татвар	237.3	198.0	-39.3
5	Ашигт малтмал/нүүрс	233.6	116.9	-116.7
6	Ус бохирдуулсны төлбөр	10.0	13.0	3.0
7	Агаарын бохирдол /авто/	132.3	160.5	28.2
8	Агаарын бохирдол /нүүрс/	125.3	67.2	-58.1
9	Агаарын бохирдол /эх үүсвэр/	3.4	3.9	0.5
Дүн		10,268.7	11,159.5	890.8

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг өмнөх оны гүйцэтгэлээс 890.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

Аудитаар орон нутгийн төсвийн орлогын саналыг бодит тооцоо судалгаанд үндэслэн тооцсон эсэхийг хянаж үзэхэд дараах зөрчил илэрлээ.Үүнд:

- Орон нутгийн төсвийн орлогын саналыг өмнөх оны орлогын гүйцэтгэлтэй уялдуулж төлөвлөөгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 19 өдрийн 244 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулахад баримтлах журам”-ын 4.2-т “Суурь төсвийн саналыг дунд хугацаагаар тооцож, дараах байдлаар боловсруулна” гэж заасантай нийцэхгүй байна.
- ААН-ийн орлогын албан татварын төлөвлөгөөг 40 хувиар тооцон үзэхэд аймагт ногдох орлогыг 196.0 сая төгрөгөөр илүү төлөвлөсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 “Аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотын төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ:.. 23.6.10.аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувь” гэж заасныг хангахгүй байна.

Орон нутгийн төсвийн орлогын саналыг Сангийн яаманд хүргүүлэхдээ өмнөх оны гүйцэтгэлээс 31,794.6 сая төгрөгөөр бууруулж тооцсон, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 196.0 сая төгрөгөөр илүү тооцсон зэргээс харахад өмнөх оны гүйцэтгэл, татварын болон бусад эх үүсвэрээс орох орлогыг бүрэн тооцож төлөвлөхгүй байна.

1.2 Орон нутгийн төсвийн зарлагын саналыг өмнөх оны орлогын гүйцэтгэлээс 71,417.5 сая төгрөгөөр нэмж боловсруулж хүргүүлсэн байна.

1.2.1 Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагын төсвийн саналыг 167,066.0 сая төгрөгөөр нэгтгэн төлөвлөж Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Төсвийн зардлыг баталсан байдлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №-3а Төсвийн нийт зардлын төлөвлөгөө

/сая.төг/

Зардлын үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	2025 оны Төсвийн санал	Өөрчлөлт
1	2	3	4=3-2
А.УРСГАЛ ЗАРДАЛ	69,180.0	142,935.3	73,755.3
Бараа ажил үйлчилгээний зардал	61,806.9	118,060.1	56,253.2
Татаас	3,632.0	2,726.9	-905.1
Урсгал шилжүүлэг	3,741.1	22,148.3	18,407.2
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	25,331.0	24,108.5	-1,222.5
В.ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,137.5	22.2	-1,115.3
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	95,648.5	167,066.0	71,417.5

Зардлыг өмнөх оны гүйцэтгэлээс 71,417.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн нь харьяа байгууллагууд төсвийн төслөө бодит тооцоо, судалгаанд үндэслэн боловсруулахгүй байгааг харуулж байна.

1.2.2 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн III/31 дүгээр тогтоолоор Хөвсгөл аймгийн төсвийг 141,868.4 сая төгрөгөөр баталсан байна

Хүснэгт №-3б Төсвийн нийт зардлын төлөвлөгөө

/сая.төг/

Зардлын үзүүлэлт	2025 оны Төсвийн санал	2025 оны Анх баталсан төсөв	Өөрчлөлт
1	2	3	4=3-2
А.УРСГАЛ ЗАРДАЛ	142,935.3	84,842.1	-58,093.2
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	24,108.5	54,341.8	30,233.3
В.ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	22.2	2,684.5	2,662.3
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	167,066.0	141,868.4	-25,197.7

Төсвийн зарлагыг төсвийн төслөөс 25,197.7 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

Харьяа байгууллагуудын зардлыг батлахдаа төвийн саналаас урсгал зардлыг 58,093.2 сая төгрөгөөр бууруулж, эргэж төлөгдөх цэвэр зээлийг 2,662.3 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 30,233.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн нь урсгал зардлыг хасаж, хөрөнгө оруулалтад зарцуулах замаар төсвийн үр ашгийг дээшлүүлэх зорилт тавьсан байна.

1.3 Орон нутгийн төсөвт 4,615.5 сая төгрөгийн хасах тодотголыг хийсэн ба үүний 75.9 хувь нь байр ашиглалттай холбоотой зардлыг бууруулсан байна.

1.3.1 Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1¹ заалтыг үндэслэн аймгийн ИТХ-ын хуралдааны 2025 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 74 дүгээр тогтоолоор 2025 оны төсөвт тодотгол хийсэн байна. Төсвийн тодотголын орлогын төрлийг харуулбал:

Хүснэгт №-4 Төсвийн тодотгол

/сая.төг/

Орлогын төрөл		Анх батлагдсан төсөв	Тодотгосон төсөв	зөрүү	
				дүн	Хувь
1	Санхүүгийн дэмжлэг	52,173.4	38,599.9	13,573.5	26.0
2	ОНХС-ийн орлогын шилжүүлэг	20,848.6	14,457.7	6,390.9	30.7
3	Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт		1,678.1	-1,678.1	
4	Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого	1,817.0	152.5	1,664.5	91.6

¹ дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон

5	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	24,179.4	33,170.2	-8,990.8	-37.2
6	Орон нутгийн орлого	42,850.0	49,194.5	-6,344.5	-14.8
Нийт орлого		141,868.4	137,252.9	4,615.5	3.3
1	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	31,708.7	30,798.0	910.7	2.9
2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,974.5	3,856.3	118.2	3.0
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,765.0	18,261.5	3,503.5	16.1
4	Хангамж, бараа материалын зардал	1,920.0	1,909.7	10.3	0.5
5	Нормативт зардал	320.6	304.5	16.1	5.0
6	Эд хогшил, урсгал засварын зардал	2,349.4	2,086.8	262.6	11.2
7	Томилолт, зочны зардал	605.5	556.0	49.5	8.2
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,288.4	9,176.7	111.7	1.2
9	Бараа үйлчилгээний бусад зардал	4,407.7	4,016.1	391.6	8.9
10	ТАТААС	4,220.5	4,887.1	-666.6	-15.8
11	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,281.8	4,233.3	48.5	1.1
12	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	54,341.8	54,345.4	-3.6	0.0
13	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	2,684.5	2,821.3	-136.9	-5.1
Нийт зардал		141,868.4	137,252.9	4,615.5	3.3

Хүснэгтээс харахад:

- Орон нутгийн төсвийг тодотгож батлахдаа санхүүгийн дэмжлэгийг 13,573.5 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг 6,390.9 сая төгрөгөөр, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг 1,664.5 сая төгрөгөөр бууруулж, хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг 1,678.1 сая төгрөгөөр, орон нутгийн орлогыг 6,344.5 сая төгрөгөөр, өмнөх оны үлдэгдлээс санхүүжих дүнг 8,990.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна. Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогын ангиллыг сольж баталсан байна.
- Албан хаагчидтай холбоотой цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг 1,028.9 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой зардлыг 3,503.5 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 262.6 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийг 111.7 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 391.6 сая төгрөгөөр тус тус бууруулсан байна.

Төсвийн тодотгол хийхдээ байр ашиглалттай холбоотой зардлыг 3,503.5 сая төгрөгөөр бууруулсан нь нийт өр төлбөрийг нэмэгдүүлсэн, төрийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй, дараагийн төсвийн жилд сөрөг нөлөө үзүүлэхүйц шийдвэр болсон байна.

Төсөвт хийсэн зохицуулалтын талаар:

Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2², Хөвсгөл аймгийн Засаг даргын 2025 оны А/334, А/686 дугаар захирамжуудаар орон нутгийн төсөвт нийт 2 удаагийн зохицуулалтыг хийсэн байна.

Төсөвт хийсэн зохицуулалтыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №5

Зардлын зүйл	/сая төгрөгөөр/		
	нэмэх	хасах	Дүн
Цалин, хөлс болон нэмэгдэл	452.2	-341.2	111.1
Нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11.0	0	11.02
Байр ашиглалттай холбоотой	0.5	-110.9	-110.4
Хангамж, бараа материалын зардал	26.3	-18.3	8.0

² Төсвийн захирагч төсөвтөө дараах байдлаар зохицуулалт хийж болно,

Нормативд зардал	0	-9.5	-9.5
Эд хогшил, урсгал засварын зардал	131.7	-11.1	120.6
Томилолт, зочны зардал	5.7	-1.0	4.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	4.5	-144.9	-140.4
Бараа үйлчилгээний бусад зардал	-	-38.3	-38.3
Урсгал шилжүүлэг	120.5	-77.4	43.1
Дүн	752.5	-752.5	0.00

Төсвийн зардалд хийсэн зохицуулалтыг харахад цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллын зардлыг 111.0 сая төгрөг, хангамж бараа материалын зардлыг 8.0 сая, эд хогшил урсгал засварын зардлыг 120.6 сая, томилолтын зардлыг 4.7 сая, урсгал шилжүүлгийн зардлыг 43.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж бусад зардлыг хассан байна.

Орон нутгийн төсөвт хийсэн зохицуулалт нь Сангийн сайдын 2019 оны 134 дүгээр тушаалаар баталсан журамд нийцэж байна.

Төсвийн тодотгол, зохицуулалтыг хууль журмын дагуу хийсэн эсэхийг хянан үзэхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагууд, улсын төсвийн байгууллагын тогтмол зардалд төсвийн жилийн дундуур тооцоо судалгаанд үндэслэлгүй 3,503.5 сая төгрөгийн хасах тодотгол хийсэн, халаалтын нэгж талбайн үнийг нэмж тооцсоноос 3,683.8 сая төгрөгийн өр төлбөр үүссэн нь цаашид орон нутгийн төсөвт хүндрэл учруулах нөхцөл байдлыг бий болгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 14.2.3 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах" заалтыг хангахгүй байна.

1.3.2 Төсвийн гүйцэтгэлийн тайланг тайлант оноос www.finperform.gov.mn цахим системээр нэгтгэж эхэлсэн байна. Аймгийн ИТХ-аар баталсан төсөв болон цахим системийн төлөвлөгөөг харьцуулж харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №6

/сая төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Батлагдсан төлөвлөгөө	Finperform программ	Зөрүү
Татварын орлого	46,699.3	46,699.3	-
Нийтлэг татварын бус орлого	37,478.5	4,308.3	33,170.2
Хөрөнгийн орлого	17.6	17.6	-
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	14,457.7	14,457.7	-
Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	38,599.9	38,599.9	-
НИЙТ ЭХ ҮҮСВЭР	137,253.0	104,028.8	-
УРСГАЛ ЗАРДАЛ	80,086.2	80,086.2	-
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	54,345.4	54,345.4	-
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	2,821.3	2,821.3	-
НИЙТ ЗАРДАЛ	137,252.9	104,082.7	-

Хүснэгтээс харахад аймаг сумдын ИТХ-аас батлагдсан Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвөөс, Finperform программд шивсэн төсвийн төлөвлөгөө 33,170.2 сая төгрөгийн зөрүүтэй байна. Энэ нь төсвийн зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэрийн урд оны үлдэгдлээс санхүүжих дүнг программ хөгжүүлэлттэй холбоотой татагдахгүй байгаа тул аудитаар зөрчилд тооцоогүй болно.

Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагууд, улсын төсвийн байгууллагын тогтмол зардалд төсвийн жилийн дундуур тооцоо судалгаанд үндэслэлгүй 3,503.5 сая төгрөгийн хасах тодотгол хийсэн, халаалтын нэгж талбайн үнийг нэмж тооцсоноос 3,683.8 сая төгрөгийн өр төлбөр үүссэн нь цаашид орон нутгийн төсөвт хүндрэл учруулах нөхцөл байдлыг бий болгосон байна. Харин зохицуулалтыг төсвийн ихэнх зардлын эдийн засгийн ангилалд хийсэн байгаагаас харахад төсвийн төлөвлөлтийг үндэслэлтэй боловсруулж, батлахгүй байгаагаар холбоотой байна.

БҮЛЭГ 2: ОРОН НУТГИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ 6,321.1 САЯ ТӨГРӨГӨӨР БУЮУ 12.8 ХУВИАР ДАВУУЛАН БИЕЛҮҮЛСЭН БАЙНА.

2.1 Орон нутгийн орлогын төлөвлөгөөг 6,321.1 сая төгрөгөөр буюу 12.8 хувиар давуулан биелүүлсэн байна.

2.1.1 Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд нийт орлогын гүйцэтгэлийг 145,189.8 сая төгрөгөөр тайлагнасан байна.

Хөвсгөл аймгийн орон нутгийн төсвийн эх үүсвэрийг 137,252.9 сая төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 145,189.8 сая төгрөгийн төсвийг бүрдүүлэн 105.8 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна. Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг 14,457.7 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 14,335.9 сая төгрөг олгож 121.8 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон байна.

Аймгийн орон нутгийн төсвийн эх үүсвэрийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №-7 Төсвийн гүйцэтгэлийг санхүүжүүлэх эх үүсвэр

/сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэлээр	2025 он		2025 оны биелэлт	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	37,957.8	38,599.9	38,599.9	-	100.0
Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	16,065.8	14,457.7	14,335.9	(121.8)	99.2
Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого	3,281.1	1,830.6	3,568.2	1,737.6	194.9
Урьд оны үлдэгдлээс санхүүжих		33,170.2	33,170.2	-	100.0
Орон нутгийн төсвөөс санхүүжих	40,604.4	49,194.5	55,515.6	6,321.1	112.8
Дүн	97,909.1	137,252.9	145,189.8	7,936.9	105.8

Хүснэгтээс харахад тайлант онд урьд оны үлдэгдлээс олгох санхүүжилт болон улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг бүрэн санхүүжүүлсэн байна.

Төсвийн эх үүсвэрийг графикаар үзүүлбэл:



Төсвийн санхүүжүүлсэн эх үүсвэрийн 38.5 хувийг орон нутгийн төсвийн орлого, 26.8 хувийг улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, 9.9 хувийг орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг, 2.3 хувийг урд оны үлдэгдлээс санхүүжих, 2.5 хувийг үйл ажиллагааны орлогын санхүүжилт тус тус эзэлсэн байна.

2.1.2 Тайлант онд 49,194.5 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөсөн ба 55,515.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 6,321.1 сая төгрөгөөр давуулан биелүүлж, 112.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт №-8 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

/сая.төг/

Орлогын төрөл	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны төлөвлөгөө	Тайлант оны Гүйцэтгэл	Зөрүү		Хувь
1	2	3	4	5=4-2	6=4-3	7
Татварын орлого	56,571.2	46,699.3	52,334.4	-4,236.8	5,635.1	112.1
Татварын бус орлого	2,962.8	2,477.6	3,107.9	145.1	630.3	125.4
Хөрөнгийн орлого	102.8	17.6	73.3	-29.5	55.7	416.5

Нийт дүн	59,636.8	49,194.5	55,515.6	-4,121.2	6,321.1	112.8
----------	----------	----------	----------	----------	---------	-------



Орон нутгийн орлогын төлөвлөгөө давж биелэхэд татварын орлого 5,635.1 сая төгрөгөөр давж биелсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

2025 оны төсвийн орлогын гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулахад 4,121.2 сая төгрөгөөр буурсан байна.

Нийт орлогын 93 хувийг сумдын орлого, 7 хувийг аймгийн орлогоос бүрдүүлсэн байна.

Орон нутгийн төсөвт 49,194.5 сая төгрөгийн 24 нэр төрлийн орлогыг бүрдүүлэхээр төлөвлөснөөс 17 нэр төрлийн орлого 7,052.4 сая төгрөгөөр давж биелсэн ба үүнд цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй

адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 2,254.9 сая төгрөг, Ойн нөөц ашигласны төлбөр 2,538.2 сая төгрөгөөр давсан нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх 7 нэр төрлийн орлогын төлөвлөгөөний биелэлт 723.2 сая төгрөгөөр тасарсан байна. Нэр төрлөөрөө тасарсан орлогыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №-9 Нэр төрлөөрөө тасарсан орлого:

/сая.төг/

№	Орлогын нэр төрөл	2025 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	тасралт	хувь
1	Хөрөнгийн орлого	3,333.6	3,137.3	(196.4)	94.1
2	Хөрөнгө борлуулсны орлого	783.2	757.9	(25.3)	96.8
3	Шууд бус орлого	3,230.5	3,182.4	(48.1)	98.5
4	ААН-ын орлогын албан татвар	2,060.0	1,776.7	(283.3)	86.2
5	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	70.4	66.7	(3.8)	94.7
6	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1,644.0	1,482.7	(161.3)	90.2
7	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	45.0	40.0	(5.0)	88.8
Дүн		11,166.8	10,443.6	(723.2)	93.5

Орлого нэр төрлөөр тасрахад дараах татварын орлогын төрлүүдийн орлого тасарсан нь гол нөлөө үзүүлсэн байна. Үүнд:

Хөрөнгийн орлого: Хөрөнгийн орлогын татварын төлөвлөгөөний биелэлт 196.4 сая төгрөгөөр дутуу биелсэн байна. Энэ нь иргэн, ААН-ийн хадгаламжийн хэмжээ буурсантай холбоотой байна.

ААН-ийн орлогын албан татвар: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын төлөвлөгөө 283.3 сая төгрөгөөр дутуу биелэхэд аж ахуйн нэгжүүдийн орлого төлөвлөсөн хэмжээнээс буурсан, орлогын төлөвлөгөөг өндөр тогтоосноос шалтгаалсан байна. Тухайлбал: Могойн гол ХК нь алдагдалтай ажилласан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Хог хаягдлын үйлчилгээний хураамж: Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогын төлөвлөгөө 161.3 сая төгрөгөөр дутуу биелэхэд тухайн орлого он дамжиж орсон, мөн Эрчим хүч ХХК-ийн айл өрхүүдээс авах авлага төлөгдөөгүй зэрэг нөлөөлсөн байна.

Орон нутагт төвлөрүүлэх 7 нэр төрлийн 723.2 сая төгрөгийн татварын орлогын төлөвлөгөөг дутуу биелүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.1.3 Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.10 дахь заалтын дагуу аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувийг аймгийн орон нутгийн орлогод хуваарилахаар заасан байна.Тайлант онд аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас нийт 4,425.7 сая төгрөг төвлөрснөөс улсын төсөвт 2,649.0 сая төгрөг, аймгийн төсөвт 1,776.7 сая төгрөгийн хуваарилсан нь хууль тогтоомжтой нийцэж байна.

2.2 Улсын төсөвт төвлөрүүлэх 3 нэр төрлийн орлогын төлөвлөгөөг 184.7 сая төгрөгөөр дутуу биелүүлсэн байна.

Хөвсгөл аймгийн 2025 оны улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг нийт 11,159.5 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 11,340.6 сая төгрөгийг төвлөрүүлж 141.6 сая төгрөг буюу 101.6 хувийн биелэлттэй байна. Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлтийг татварын төрлөөр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №-10. Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт

/сая.төг/

№	Татварын төрөл	Өмнөх оны гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	ААНОАТ	2353.4	2,600.0	2,649.0	49.0	101.9
2	Суутгасан ААНОАТ	15.4	-	39.5		
3	НӨАТ	7,158.0	8,000.0	8,273.6	273.6	103.4
4	Онцгой албан татвар	237.3	198.0	201.4	3.4	101.7
5	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр/нүүрс	233.6	116.9		-116.9	0.0
6	Ус бохирдуулсны төлбөр	10	13	13.3	0.3	102.3
7	Агаарын бохирдол /авто/	132.3	160.5	159.9	-0.6	99.6
8	Агаарын бохирдол /нүүрс/	125.3	67.2	0	-67.2	0.0
9	Агаарын бохирдол /эх үүсвэр/	3.4	3.9	3.9	0.0	100.0
Дүн		10,268.7	11,159.5	11,340.6	141.6	101.6

Хүснэгтээс харахад улсын төсөвт төвлөрүүлэх татварын орлогын 9 нэр төрлийн орлогын төлөвлөгөөнөөс 6 нэр төрлийн орлого 326.3 сая төгрөгөөр давж, 3 нэр төрлийн орлого 184.7 сая төгрөгөөр тасарсан байна. Улсын төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг нэр төрлөөр нь бүрэн биелүүлээгүйд Могойн гол ХК-ийн санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын албан татвараа төлөөгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.

- Улсын төсөвт төвлөрүүлэх 3 нэр төрлийн орлогын төлөвлөгөөг 184.7 сая төгрөгөөр дутуу биелүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1. "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Орон нутгийн орлогын төлөвлөгөөг 6,321.1 сая төгрөгөөр буюу 112.8 хувиар биелүүлсэн боловч 7 төрлийн 723.2 сая төгрөгийн орлогыг тасалсан, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт дүнгээр нь 141.6 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч 3 нэр төрлийн орлогын төлөвлөгөөг 184.7 сая төгрөгөөр тасалсан нь бүх шатны төсөв захирагч нар нь Төсвийн тухай хуулиар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлээгүйг харуулж байна.

БҮЛЭГ 3: ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, ХУДАЛДАН АВАЛТ, ЗАРЦУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ 3,670.5 САЯ ТӨГРӨГИЙН ЗӨРЧИЛ ИЛЭРСЭН БАЙНА.

3.1. Төсвийн зардлын гүйцэтгэл 117,719.0 сая төгрөг буюу 85.8 хувьтай хэрэгжсэн байна.

3.1.1. Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн 1/645 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Аудитаар төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн тайланг иж бүрэн ирүүлсэн эсэхийг шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ❖ Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн иж бүрдэл болох хөтөлбөр, төсвийн захирагч, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр 2025 оны төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, Хөвсгөл аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд

хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгааныг тус тус ирүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.4, 54.5.5 дахь заалттай нийцэхгүй байна.

Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд нийт эх үүсвэрийг 112,019.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 117,719.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Аудитаар төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв нэгтгэж, тайлагнасан эсэхийг хянахад дараах алдаа илэрснийг аудитаар залруулж ажилласан. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт орлогыг 707.9 сая төгрөгөөр дутуу тайлагнасан байна.
- Нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн орлогын дүнг 64.5 сая төгрөгөөр илүү дүнтэй тайлагнасан

Дээрх алдаа нь Төсвийн тухай хуулийн 6.3.2 "Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах" заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Хөвсгөл аймгийн 2025 оны нийт зардлын төлөвлөгөө 137,252.9 сая төгрөг, гүйцэтгэл 117,719.0 сая төгрөг буюу 85.8 хувийн биелэлттэй байна. Төсвийн зардлын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №-11. Төсвийн гүйцэтгэл зардлын нэр төрлөөр /сая.төг/

Зардлын үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	2025 оны нэгдсэн тайлангаар			
		Төл	Гүйц	Зөрүү	Хувь
1	2	3	4	5=4-2	6
А.УРСГАЛ ЗАРДАЛ	69,180.0	80,086.2	74,972.8	5,792.8	93.6
Бараа ажил үйлчилгээний зардал	61,806.9	70,925.8	66,253.8	4,446.9	93.4
Татаас	3,632.0	4,919.2	4,911.0	1,279.0	99.8
Урсгал шилжүүлэг	3,741.1	4,241.2	3,808.0	66.9	89.8
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	25,331.0	54,345.4	40,166.7	14,835.7	73.9
В.ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,137.5	2,821.3	2,579.5	1,442.0	91.4
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	95,648.5	137,252.9	117,719.0	22,070.5	85.8

Төсвийн зарлагын гүйцэтгэл өмнөх онд 95,648.5 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 117,719.0 сая төгрөг болж өмнөх оноос 22,070.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийг зардлын бүлгийн дүнгээр нь харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №-12 /сая.төгрөгөөр/

Зардлын зүйл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	30,921.6	29,779.1	1,142.6	96.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,873.3	3,726.3	147.0	96.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,274.5	17,714.4	560.0	96.9
Хангамж, бараа материалын зардал	1,848.3	1,443.2	405.1	78.1
Нормативт зардал	301.2	257.3	43.9	85.4
Эд хогшил, урсгал засварын зардал	2,142.7	1,975.7	166.9	92.2
Томилолт, зочны зардал	554.0	429.9	124.1	77.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,018.7	7,521.7	1,497.0	83.4
Бараа үйлчилгээний бусад зардал	3,991.6	3,406.3	585.3	85.3
ТАТААС	4,919.2	4,910.9	8.3	99.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,241.2	3,808.0	433.2	89.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	54,345.4	40,166.8	14,178.7	73.9
Эргэж төлөгдөх зээл	2,821.3	2,579.5	241.8	91.4
НИЙТ ЗАРЛАГА	137,252.9	117,719.0	19,534.0	85.8

Төсвийн зардлын гүйцэтгэл 85.8 хувьтай байгаа нь цалин урамшууллын зардал 1,142.6 сая, ажил олгогчийн шимтгэл 147.0 сая, тогтмол зардал 560.0 сая, хангамжийн материалын зардал 78.1 сая төгрөг, нормативд зардал 85.4 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 92.2 сая, томилолт зочны зардал 77.6 сая т өгрөг, бусдаар гүйцэтгүүлэх арга хэмжээний зардал 83.4 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 83.4 сая, хөрөнгийн зардал 73.9 сая, хоршоо хөгжүүлэх сангийн зээл олголт 91.4 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсан нь нөлөөлсөн байна.

Аудитаар зарцуулалттай холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ❖ Аймгийн газрын харилцаа барилга хот байгуулалтын газраас Виктор мэд ХХК-тай Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон 15 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах гэрээг байгуулсан ба гэрээний дагуу 8 сумдаас 151.9 сая төгрөгийг 2025 онд шилжүүлсэн боловч тус ажлын хэрэгжилт ямар шатанд яваа нь тодорхойгүй байна. Ажил гүйцэтгэх хуваарийн дагуу 2026 оны 3 дугаар сард сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах ёстой боловч хэрэгжүүлээгүй байна.

Мал хамгаалах сангийн төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар:

Аймгийн ИТХ-ын тогтоолоор Мал хамгаалах сангийн төсвийн орлого, зарлагыг 190.0 сая төгрөгөөр баталж, үүнээс орон нутгийн төсвийн хөрөнгөөс 150.0 сая төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлогоос 40.0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 160.0 сая төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлогоос 1.0 сая төгрөгийн орлого олж, 160.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Мал хамгаалах сангийн зарцуулалтыг хянан үзэхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ❖ Мал хамгаалах сан өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 39.0 сая төгрөгөөр дутуу биелүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1. "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.
- ❖ Мал хамгаалах сан нь төсөвт тодотгол, зохицуулалт хийхгүйгээр орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг 10.0 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3 "Урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх" заалтыг зөрчсөн байна.

Түрээсийн орон сууцны эргэлтийн сангийн талаар:

Хөвсгөл аймгийн Засаг дарга нь "Шинэ Мөрөн" хорооллын 135 айлын орон сууц, 34 автомашины гаржийг худалдан авах гэрээг Монгол Улсын Хөгжлийн банкттай 2020 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр үл хөдлөх эд хөрөнгийн үндсэн үнийг 9,549.6 сая төгрөг, хугацааг 5 жил, жилийн 6 хувийн хүү /авлагын үлдэгдлийн бодит үлдэгдлээс тооцох/, хуваарийн дагуу төлөөгүй хэтрүүлсэн зээлийн дүнгийн 0.1 хувиар хоног тутам алданги, хагас жил тутам үндсэн төлбөр хүүгийн хамт төлөхөөр гэрээ байгуулсан байна.

Түрээсийн орон сууцны эргэлтийн сангийн хөрөнгийн тайлагналтай холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ❖ Хөгжлийн банканд төлдөг зээл, хүүгийн төлбөр, иргэдийн орон сууц худалдан авах гэрээний дагуу хүлээн авч байгаа орлогыг төсвийн орлого, зардлын төлөвлөгөөнд тусгаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.3.3 "төсвийн орлогоор баталгаажсан Засгийн газрын өрийн баталгаа, гадаад зээл, бүх төрлийн санхүүгийн үүрэгтэй холбогдсон гэрээ, хэлцэл, үйл ажиллагааг төсөвт тусгах", заалтыг хангахгүй байна.
- ❖ Түрээсийн орон сууцнаас иргэдтэй худалдах, худалдан авах гэрээ хийгээгүй 1,511.2 м2 талбай бүхий 30 орон сууц үлдсэн нь цаашид Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт Хөгжлийн банкны хүү болон алдангийн төлбөрийг төлөх эрсдэл учруулахаар байна.

Төрд учирсан хохирлын талаар: Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн хяналтад байдаг байгууллагуудын санхүүгийн тайланд ажлаас үндэслэлгүйгээр халагдсан нь Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д заасны дагуу ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг төсвөөс олгож буруутай албан тушаалтнаас авах авлагаар бүртгэсэн хэдий ч байгууллагад учирсан хохирлыг барагдуулаагүй иргэнтэй холбоотой 180.5 сая төгрөг, Хөрөнгө оруулалттай холбоотой 33.0 сая төгрөг нийт 213.5 сая төгрөгийн авлагын эхний үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант онд авлагын үлдэгдэл 11.0 сая төгрөгөөр буурч 202.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. /Хавсралт №5-аас харах/ СТ-д

Дээрх авлага нь 2019-2025 оны хооронд үүссэн хэдий ч барагдуулаагүй олон жил болсон нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.2.Энэ “хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Төрд учирсан хохирлыг бүрэн нөхөн төлүүлсэн тохиолдолд төсвийн эх үүсвэрийг 202.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна.

Дамжуулан зээлдүүлэх зээлийн эргэн төлөлтийн талаар:

“Хөвсгөл Эрчим хүч” ХХК-ийн 710.4 сая төгрөг, “Хөвсгөл ус суваг” ХХК-ийн 13,065.3 сая төгрөг нийт 13,775.0 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэл байна. Энэ нь Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкны төслийн зээлийн үлдэгдэл байна.

Үүнийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №-13.

/Сая.төг/

Зээлдэгч	Гэрээний дугаар	Эхний үлдэгдэл	Ханшийн зөрүү	Үндсэн төлбөр	Хүүгийн төлбөр	Үлдэгдэл
Хөвсгөл Эрчим хүч ХХК	OL-3503MOG-07	758.4		48	5.4	710.4
Дүн		758.4		48	5.4	710.4
Хөвсгөл Ус суваг ХХК	OL-1560MON-3	968.1				968.1
Хөвсгөл Ус суваг ХХК	OL-2301MON-13	421.8				421.8
Хөвсгөл Ус суваг ХХК	OL-3713MON-4	11,227.6	447.8			11,675.4
Дүн		12,617.5	447.8	0.0	0.0	13,065.3
Нийт дүн		13,375.9	447.8	48.0	5.4	13,775.7

“Хөвсгөл Эрчим хүч” ХХК нь тайлант онд 48.0 сая төгрөгийн үндсэн зээл, хүүгийн төлбөрт 5.4 сая төгрөг төлж зээлийн графикайн дагуу төлөлтийг хийсэн байна.

“Хөвсгөл ус суваг” ХХК нь тайлант онд урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 13,065.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба дээрх зээлээс үндсэн зээл, хүүгийн төлбөрийг огт төлөөгүй байна.

Аймгийн Засаг дарга, Сангийн яамтай байгуулсан гэрээнд Хөвсгөл аймагт баригдсан цэвэрлэх байгууламжийн 13,065.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс төлж барагдуулахаар байгаа нь орон нутгийн төсөвт хүндрэл учруулах нөхцөл байдлыг үүсгэж байна. Үүнээс OL-1560MON-3 дугаартай зээлийн гэрээний хугацаа 2020 онд дууссан ба хугацаа хэтэрсэн зээл 968.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн талаар:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу төсвийн байгууллагуудын нэмэлт төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд нэгтгэсэн байна.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд 2,194.1 сая төгрөгийн орлогыг хүлээн авсан байна. Үүнд:

- төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс 88.1 сая төгрөгийг, ЗГНХ, ЗДНХ түүнтэй адилтгах нөөц сангаас 35.2 сая төгрөгийг,
- Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс 1,467.9 сая төгрөгийг,
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 601.9 сая төгрөгийг,

Нэмэлт төсвийн санхүүжилтээс бараа ажил үйлчилгээний зардалд 1,987.3 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардалд 158.0 сая төгрөг, хөрөнгийн зардал 48.8 сая төгрөг нийт 2,194.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аудитаар нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлагналтай холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Нэмэлт санхүүжилтийн дансны орлогыг 64.5 сая төгрөгөөр илүү дүнтэй тайлагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.3.2-т *"Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах"* заалттай нийцэхгүй байна.

3.1.3. Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг аймгийн Аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн III/31 дүгээр тогтоолын хавсралтаар 53,012.1 сая төгрөгийн бараа ажил үйлчилгээг худалдан авахаар баталсан байна.

Орон нутгийн 2025 оны төсөвт тодотгол хийсэнтэй холбогдуулан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 11,309.8 сая төгрөгийн төгрөгийн төсөвт өртөгтэй 6 бараа, ажил үйлчилгээг нэмж худалдан авахаар тодотгол хийсэн байна.

Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2025 онд 64,321.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тайлант онд санхүүжих 46,039.8 сая төгрөгийн 72 төсөл арга хэмжээг худалдан авахаар төлөвлөсөн байна.

Хөвсгөл аймгийн худалдан авах ажиллагааны газар нь Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээнд бараа ажил үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажилласан байна. Үүнд:

- нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 63,038.4 сая төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулж, 45,041.9 сая төгрөгийн гэрээ байгуулсан,
- Харьцуулалтын аргаар 867.0 сая төгрөг тендер шалгаруулалт явуулж 652.0 сая төгрөгийг гэрээ байгуулсан,
- ШХА-ын аргаар 196.1 сая төгрөгийн бараа ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөж 195.8 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна.
- Гэрээ шууд байгуулах аргаар 150.0 сая төгрөгийн ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохин байгуулж 150.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна.

Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №14.

Хүснэгт №14.				/сая.төг/
Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан арга	тоо	төсөвт өртөг	гэрээний дүн	хэрэгжсэн тоо
Нээлттэй тендер шалгаруулалт	44	63,083.4	45,041.9	36
Харьцуулалт	15	867.0	652.0	13
Шууд худалдан авалт	12	196.1	195.8	12
Гэрээ шууд байгуулах	1	150.0	150.0	1
Нийт дүн	72	64.296.5	46.039.8	62

Хүснэгтээс харахад 72 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулж, 62 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж 10 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Худалдан авсан бараа ажил үйлчилгээний мэдээллийг худалдан авах ажиллагааны цахим систем tender.gov.mn сайтад хуульд заасан хугацаанд мэдээлсэн байна.

3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, орлогын бүрдүүлэлт, арвилан хэмнэлт үр ашигтай холбоотой 3,670.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

3.2.1. Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 4 дүгээр сарын 29-ны өдрөөс эхлэн хэрэгжиж байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа

байгууллагуудын СТА-аар хянаж үзсэн ба Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 21.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Албан хаагчдад 5.8 сая төгрөгийн хувцас хэрэглэл худалдан авсан
- Нутгийн зөвлөлийн уулзалт зохион байгуулахад 2.5 сая төгрөгийг зарцуулж төсвийн үр ашгийг бууруулсан.
- Төсвөөс 1.8 сая төгрөгөөр уралдаан тэмцээн зохион байгуулсан
- Контент хийлгэхэд 3.0 сая төгрөгийг зарцуулсан
- Гар утасны нэгж худалдан авч 0.2 сая төгрөгийн зардал гаргасан
- Бэлэг дурсгалын зүйлд 6.1 сая төгрөгийг зарцуулсан
- Төсвийн хөрөнгөөр 1.9 сая төгрөгийн хэрэгцээ шаардлагагүй материал худалдан авсан.

Тайлант онд Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн зүгээс харьяа төсвийн байгууллагуудын төсвийн зарцуулалтын үйл ажиллагаанд нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж ажиллаагүй байна.

3.2.2 Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын төсвийн зарцуулалтад аймгийн санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс болон аймгийн ЗДТГ-ын санхүү төрийн сангийн хэлтсийн дотоод хяналт тус тус хяналтыг хэрэгжүүлж байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс: Хөвсгөл аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс нь 2025 онд гүйцэтгэх “Байгууллагын 2025 оны дотоод аудит, хяналт шалгалтын төлөвлөгөө”-г Хөвсгөл аймгийн Засаг даргын дэргэдэх дотоод аудитын хорооны 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор нийт 153 объектод хяналт хэрэгжүүлж, батлуулсан байна.

Гүйцэтгэлийн шатанд Санхүүгийн хяналт аудитын албаны ажлын хэрэгжилтийг хянаж үзэхэд тайлант онд 11 дотоод аудит, 160 байгууллагад хяналтыг гүйцэтгэсэн байна. Хэрэгжүүлсэн хяналтын дүнд 328.3 сая төгрөгийн 107 төлбөрийн акт, 2,779.4 сая төгрөгийн 138 албан шаардлага хүргүүлсэн ба тайланд хугацаанд 71.1 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж, бусад төлбөрийн акт, албан шаардлага хэрэгжих хугацаа болоогүй, хэрэгжилтийн шатандаа байна.

Санхүү төрийн сангийн хэлтсийн хяналт: Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс нь сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх төлөвлөгөөг Хөвсгөл аймгийн Засаг даргын 2025 оны 01 дугаар сарын 28-ны өдрийн А/37 тоот захирамжаар батлуулж тайлант онд дараах хяналтуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Төлөвлөгөөт 11 сумын төрийн санд дотоод хяналт хийж, холбогдох албан тушаалтнуудад 101 зөвлөмжийг хүргүүлж ажилласан байна. Дотоод хяналтаар төрийн сангуудын хийж гүйцэтгэсэн гүйлгээнүүд, санхүүжилт болон тайлагналын хяналт, татварын орлогын бүрдүүлэлт, төлбөр тооцооны хяналт, төсвийн байгууллагын мөнгөн кассын хэрэгжилт, төрийн сангийн баримтын архивын нэгж бүрдүүлэлт зэрэгт хяналт хийж ажилласан байна.
- Сумын төрийн сангийн албан хаагчид болон нягтлан бодогчдыг чадавхжуулах зорилгоор ажлын байрны дадлагажуулах сургалт, “Төрийн сангийн удирдлагын цахим системийн хөгжүүлэлт” сургалт болон бүсийн сургалтуудыг зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 691 албан хаагчийг хамруулсан байна.

Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрсэн. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой 456.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

- Хуулиар заагдаагүй шагнал урамшуулал, дэмжлэгт 147.0 сая төгрөг олгосон
- Төсвийг зардлын эдийн засгийн ангилал зөрчиж 61.8 сая төгрөг зарцуулсан
- ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгийн санхүүжилтийг олгохдоо магадалшгүй ажлын баримт, акт байхгүй байхад 1.9 сая төгрөг олгосон, барьцаа суутгахгүй 5.9 сая төгрөг олгосон байна.
- Батлагдсан төсвийг 3.5 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.
- Анхан шатны баримтын бүрдэлгүй 2.6 сая төгрөг зарцуулсан байна.

- Байгууллагын үндсэн чиг үүрэгт хамааралгүй 228.1 сая төгрөгийн материал худалдан авч зарцуулсан байна.

2. Төсвийн төлөвлөлт гүйцэтгэлтэй холбоотой 201.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

- Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн нэгдсэн тайланд 2018 онд үүссэн түлш халаалтын өглөг 116.8 сая төгрөг, тайлант онд үүссэн өр төлбөрийг барагдуулахтай холбоотой зохион байгуулсан ажилгүй байна.
- Үйл ажиллагааны 6.1 сая төгрөгийн орлогыг төсөвт байгууллагын өөрийн орлогод тооцож төлөвлөөгүй.
- Буруутай шийдвэр гаргасан нь шүүхийн шийдвэрээр нотлогдож, иргэнийг хохиролгүй болгосон 32.8 сая төгрөг, малжуулах хөтөлбөрийн хүрээнд 2021 онд үүссэн 21.0 сая төгрөгийн авлагыг тус тус барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

3. Төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой нийт 2,327.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

- Сумдын ТТЗ-дийн санхүүгийн нэгдсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар Орон нутгийн орлогыг нэр төрлөөр 2,324.0 сая төгрөгөөр тасалсан.

4. Худалдан авах ажиллагаатай холбоотой 662.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

- Худалдан авах ажиллагааны босго үнийг баримлаагүй 224.5 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн.
- Худалдан авах ажиллагааг төлөвлөхдөө шууд худалдан авах аргыг ашиглах зорилгоор төсөвт өртгийг хувааж 80.7 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна
- Зах зээлийн үнээс хэт өндрөөр 357.5 сая төгрөгийн худалдан авалт хийсэн

5. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудаас 4 сумын ТТЗ нь төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй зөрчил илэрсэн.

Төсвийн шууд, төсвийн төвлөрүүлэн захирагчдын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төлөвлөлт, зарцуулалт, орлого бүрдүүлэлт, худалдан авалт, мэдээллийн ил тод байдалтай холбоотой илэрсэн зөрчилд холбогдох арга хэмжээг тухай бүр авч ажилласан.

Төсвийн тэнцэл = Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 112,019.7 сая төгрөг - Орон нутгийн төсвийн нийт зардал 117,719.0 сая төгрөг = 5,699.3 сая төгрөгийн алдагдлыг төрийн сангийн дансны үлдэгдлээс санхүүжүүлэн төсвийн тэнцлийг хангасан байна.

Үндэсний аудитын газраас 2025-2026 оны санхүүгийн тайлангийн аудитар баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгааны үр дүнгийн талаар:

- Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудаас авсан судалгаагаар хоол, унааны зардалд 1 хүнд өдрийн 3.0 -14.0 мянган төгрөгөөр тооцож, 1,708.7 сая төгрөг төлөвлөн, 1,559.6 сая төгрөг олгосон байна. Харьяа байгууллагуудаас 11 байгууллага нь албан хаагчдад хоол унааны хөнгөлөлт олгоогүй байна.
- Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 5 байгууллага нь гадаад албан томилолт зочин төлөөлөгч хүлээн авах 35 арга хэмжээнд 211.3 сая төгрөг төлөвлөснөөс 21 арга хэмжээнд 143.3 сая төгрөг зарцуулсан байна.
- Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой 202.5 сая төгрөгийн авлагатай байна.
- Сургалт цуглаанд 111 арга хэмжээ 513.1 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 95 арга хэмжээнд 463.0 сая төгрөг зарцуулсан байна.
- Хэвлэл мэдээллийн 11 байгууллагатай 63.8 сая төгрөгийн гэрээ байгуулж гүйцэтгэлээр 58.3 сая төгрөг зарцуулсан байна.
- **Бүтэц орон тооны цомхотголын талаар:**

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-нд төрийн албан хаагчийн тоог есөн хувиар бууруулна гэж тусгасан байна. Засгийн газраас баримталсан бодлого чиглэлийн дагуу Хөвсгөл аймагт нийт 83 орон тоог бууруулахаар төсвийн тодотголоор баталсан байна. Ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаагаар :

Үзүүлэлт	2025 онд анх батлагдсан	Тодотгосон:	Гүйцэтгэлээр:
Орон тоо	926	872	878

Хүснэгтээс харахад:

- Засгийн газраас баримталсан чиглэлийн дагуу 83 орон тоогоор бууруулах байсан боловч, 54 орон тоог хасаж тодотгол хийсэн байна.
- Гүйцэтгэлээр харьяа байгууллагууд 44 орон тоог бууруулсан ба үүнээс өндөр насны тэтгэвэрт гарсан 1 албан хаагч, 3 сул ажлын байрыг зарлаагүй, 40 албан хаагчийн чөлөөлсөн байна.
- Аймгийн Засаг даргаас сумдын ИТХ, ЗДТГ-ын бүтэц орон тоог баталсан шийдвэрийг шинэчилж батлаагүй, бүтэц чиг үүргийн шинжилгээг хийгээгүй тул бүтэц орон тоог 9 хувиар бууруулах бодлого хэрэгжихэд нэлээдгүй хүндрэл учруулж байна.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн талаар:

Аудитаар нийт 772.5 сая төгрөгийн алдааг аудитын хугацаанд залруулж, 1,507.2 сая төгрөгийн 14 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодох бүргэл тайлагналтай холбоотой 687.5 сая төгрөгийн алдааг илрүүлж залруулсан, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авалт, зарцуулалттай холбоотой 3,670.5 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 315.3 сая төгрөг нь материаллаг, 3,355.2 сая төгрөг нь материаллаг бус зөрчил байна.

Дүгнэлт:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн орлогын саналыг Сангийн яаманд хүргүүлэхдээ өмнөх оны гүйцэтгэлээс 31,794.6 сая төгрөгөөр бууруулж тооцсон, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 196.0 сая төгрөгөөр илүү тооцсон зэргээс харахад өмнөх оны гүйцэтгэл, татварын болон бусад эх үүсвэрээс бүрдэх орлогыг бүрэн тооцож төлөвлөхгүй байна.
2. Харьяа байгууллагуудын зардлыг батлахдаа төвийн саналаас урсгал зардлыг 58,093.2 сая төгрөгөөр бууруулж, эргэж төлөгдөх цэвэр зээлийг 2,662.3 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 30,233.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн нь урсгал зардлыг хасаж, хөрөнгө оруулалтад зарцуулах замаар төсвийн үр ашгийг дээшлүүлэхийг зорьсон байна.
3. Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагууд, улсын төсвийн байгууллагын тогтмол зардалд төсвийн жилийн дундуур тооцоо судалгаанд үндэслэлгүй хасах тодотгол хийсэн, халаалтын нэгж талбайн үнийг нэмж тооцсоноос 3,683.8 сая төгрөгийн өр төлбөр үүссэн нь цаашид орон нутгийн төсөвт хүндрэл учруулах нөхцөл байдлыг бий болгосон байна. Харин зохицуулалтыг төсвийн ихэнх зардлын эдийн засгийн ангилалд хийсэн байгаагаас харахад төсвийн төлөвлөлтийг үндэслэлтэй боловсруулж, батлахгүй байгаатай холбоотой байна.
4. Орон нутгийн орлогын төлөвлөгөөг 6,321.1 сая төгрөгөөр буюу 112.8 хувиар биелүүлсэн боловч 7 төрлийн 723.2 сая төгрөгийн орлогыг тасалсан, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт дүнгээр нь 141.6 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч 3 нэр төрлийн орлогын төлөвлөгөөг 184.7 сая төгрөгөөр тасалсан нь бүх шатны төсөв захирагч нар нь Төсвийн тухай хуулиар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлээгүйг харуулж байна.

5. Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авалт, төсвийн зарцуулалттай холбоотой 3,670.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн, төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн бэлтгэж ирүүлэхгүй байгаа зэрэг зөрчил нь шат шатны төсөв захирагч, санхүү, нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудын ажлын хариуцлага, ур чадвар, хяналт хангалтгүйг харуулж байна.
6. Хөвсгөл аймагт цэвэрлэх байгууламж барьсан гэрээний 13,065.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс төлж барагдуулах гэрээ хийсэн, түрээсийн 1,511.2 м2 талбай бүхий 30 орон сууцны худалдах гэрээг иргэдтэй хийж баталгаажуулаагүй зэрэг нь орон нутгийн төсөвт хүндрэл учруулах нөхцөл байдлыг үүсгэж болзошгүй байна.
7. Санхүүгийн тайлангийн аудитаар харьяа байгууллагуудаас авсан судалгаанаас харахад төрийн албан хаагчид хоол, унааны зардалд өдөрт 3-14 мянган төгрөгөөр тооцон олгосон, зарим байгууллага огт олгоогүй байгаа зэрэг нь харилцан адилгүй нөхцөл байдал үүсгэсэн нөгөө талаас зах зээлийн үнээс хэт доогуур байгаа нь ажиглагдаж байна. Бүтэц орон тооны талаар засгийн газраас баримталсан бодлогын хүрээнд 83 орон тоог бууруулах байсан ч гүйцэтгэлээр 44 орон тоог бууруулж гүйцэтгэл нь 54 хувьтай байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч буюу аймгийн Засаг дарга Л.Төмөрбаатар-т:

1. Төсвийг өмнөх оны гүйцэтгэл болон бодит тооцоо судалгаа, хууль журамд нийцүүлэн, хэмнэлттэй, үр ашигттай байхаар төлөвлөхөд анхаарч ажиллах
2. “Хөвсгөл ус суваг” ХХК-ийн 13,065.2 сая төгрөгийн үлдэгдэл байгаа ба энэ нь Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкны төслийн зээлийг орон нутгийн төсвийн нөөц бололцоогоор санхүүжүүлэх боломжтой эсэхэд дүн шинжилгээ хийж, улсын төсөв болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлэх боломжийг судалж, өр төлбөрийг барагдуулах талаар арга хэмжээг авч ажиллах
3. Халаалтын зардлыг нэмэгдсэн үнэ тарифаар санхүүжүүлэх боломжтой эсэхэд дүн шинжилгээ хийж, дулааны үнэ тарифыг бууруулах талаар эрчим хүчний зохицуулах зөвлөлтэй хамтран ажиллаж, өр төлбөрийг барагдуулах талаар арга хэмжээг авч ажиллах
4. Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн хяналтад байдаг байгууллагуудын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилд хүргүүлсэн аудитын шийдвэрийг заасан хугацаанд бүрэн хэрэгжүүлэх талаар чиглэл хүргүүлж ажиллах
5. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон 15 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хугацаанд нь хангуулах
6. Засгийн газраас баримталсан бодлогын хүрээнд бүтэц орон тоог 9 хувиар бууруулахад орон нутагт гарч болох үр дүнг тооцон ажиллах

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Г.Базар-т:

7. Төсвийг өмнөх оны гүйцэтгэл болон бодит тооцоо судалгаа, хууль журамд нийцүүлэн, хэмнэлттэй, үр ашигттай байхаар төлөвлөж нэгтгэн төсвийн саналыг Сангийн яаманд хүргүүлэх, аймагт ногдох аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөж, гүйцэтгэлийг хангуулахад хяналт хэрэгжүүлж ажиллах
8. Эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг нэмэгдүүлэхгүй байх

Хөвсгөл аймгийн Татварын газрын дарга Ч.Хуншагай-д:

9. Улс, орон нутгийн төсөвт оруулах татварын орлогыг үндэслэлтэй төлөвлөж, нэр төрөл бүрээр бүрэн хангаж ажиллах

Хөвсгөл аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга А.Догсмаа, аймгийн төрийн албаны салбар зөвлөл-д

10. Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн хяналтад байдаг байгууллагуудын удирдлагуудын буруутай шийдвэр гаргаж албан хаагчдыг ажлаас халсан, хөрөнгө оруулалттай холбоотой 202.5 сая төгрөгийн төрд учирсан хохирлыг барагдуулах арга хэмжээг авч ажиллах.

Орон нутгийн өмчийн газрын дарга Ц.Бэхбат-д:

11. Иргэдийн орон сууц худалдан авах гэрээний эргэн төлөлтийн хуваарийн дүнгээр үйл ажиллагааны орлого болон Хөгжлийн банканд төлөх зээл, хүүгийн төлбөрийг төлөвлөж байх

12. Түрээсийн орон сууцыг иргэдэд худалдан борлуулах гэрээг байгуулж дуусгах

Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогч Л.Батжаргал-д:

13. Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуульд заасны дагуу иж бүрэн ирүүлж байх

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/Мян.төг/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	137,252,944.6	112,019,668.8	(25,233,275.8)	81.6
11	Татварын орлого	46,699,251.5	52,334,387.8	5,635,136.3	112.1
110	Орлогын албан татвар	33,294,172.0	35,165,154.2	1,870,982.2	105.6
12	Татварын бус орлого	90,553,693.1	59,685,281.0	(30,868,412.1)	65.9
120	Нийтлэг татварын бус орлого	37,478,501.4	6,676,081.3	(30,802,420.1)	17.8
120003	Торгуулийн орлого	1,705,000.0	1,763,335.3	58,335.3	103.4
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	1,661,942.5	3,391,174.8	1,729,232.3	204.0
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	168,689.0	177,044.8	8,355.8	105.0
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	33,170,223.6	-	(33,170,223.6)	-
120005	Түрээсийн орлого	124,900.0	146,561.8	21,661.8	117.3
120009	Бусад орлого	647,746.3	1,197,964.5	550,218.2	184.9
121	Хөрөнгийн орлого	17,600.0	73,348.8	55,748.8	416.8
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	17,600.0	73,348.8	55,748.8	416.8
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	53,057,591.7	52,935,851.0	(121,740.7)	99.8
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	14,457,658.7	14,335,918.0	(121,740.7)	99.2
123003	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	38,599,933.0	38,599,933.0	-	100.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	137,252,944.6	117,718,970.8	(19,533,973.8)	85.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	80,086,177.8	74,972,715.0	(5,113,462.8)	93.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	70,925,842.9	66,253,835.9	(4,672,007.0)	93.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	30,921,626.0	29,779,053.3	(1,142,572.7)	96.3
210101	Үндсэн цалин	17,848,602.1	16,198,298.7	(1,650,303.4)	90.8
210102	Нэмэгдэл	10,543,795.9	11,286,140.7	742,344.8	107.0

210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,022,249.0	1,018,760.8	(3,488.2)	99.7
210104	Урамшуулал	1,459,827.9	1,233,341.1	(226,486.8)	84.5
210105	Гэрээт ажлын хөлс	47,151.1	42,512.0	(4,639.1)	90.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,873,270.5	3,726,250.9	(147,019.6)	96.2
210201	Тэтгэврийн даатгал	2,637,990.3	2,553,874.2	(84,116.1)	96.8
210202	Тэтгэмжийн даатгал	308,820.0	298,999.1	(9,820.9)	96.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	155,961.2	151,613.2	(4,348.0)	97.2
210204	Ажилгүйдлийн даатгал	152,859.4	143,654.0	(9,205.4)	94.0
210205	Эрүүл мэндийн даатгал	617,639.6	578,110.4	(39,529.2)	93.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,274,481.8	17,714,437.3	(560,044.5)	96.9
210301	Гэрэл, цахилгаан	2,240,229.6	1,960,588.9	(279,640.7)	87.5
210302	Түлш, халаалт	15,076,128.9	14,872,155.7	(203,973.2)	98.6
210303	Цэвэр, бохир ус	958,123.3	881,692.7	(76,430.6)	92.0
2104	Хангамж, бараа материалын зардал	1,848,347.6	1,443,222.8	(405,124.8)	78.1
210401	Бичиг хэрэг	291,165.9	200,609.0	(90,557.0)	68.9
210402	Тээвэр, шатахуун	1,000,515.6	802,410.7	(198,104.9)	80.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	151,588.4	128,027.7	(23,560.7)	84.5
210404	Ном, хэвлэл	4,985.2	1,795.8	(3,189.4)	36.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	112,566.6	84,671.3	(27,895.3)	75.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	287,525.9	225,708.4	(61,817.5)	78.5
2105	Нормативт зардал	301,191.1	257,275.8	(43,915.3)	85.4
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,279.6	962.8	(316.8)	75.2
210502	Хоол, хүнс	204,384.7	169,154.0	(35,230.7)	82.8
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	95,526.8	87,159.0	(8,367.8)	91.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,142,651.8	1,975,713.4	(166,938.4)	92.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	266,688.7	225,180.1	(41,508.6)	84.4
210602	Тавилга	87,262.0	69,095.3	(18,166.7)	79.2
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,100.0	2,600.0	(500.0)	83.9
210604	Урсгал засвар	1,785,601.1	1,678,838.0	(106,763.1)	94.0
2107	Томилолт, зочны зардал	553,968.2	429,916.5	(124,051.7)	77.6
210702	Дотоод албан томилолт	470,168.2	374,030.4	(96,137.8)	79.6
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	83,800.0	55,886.1	(27,913.9)	66.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,018,673.5	7,521,674.0	(1,496,999.5)	83.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	8,874,702.0	7,431,132.9	(1,443,569.1)	83.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	19,626.0	1,209.6	(18,416.4)	6.2
210803	Даатгалын үйлчилгээ	14,694.3	12,663.9	(2,030.4)	86.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	10,848.6	5,769.2	(5,079.4)	53.2
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	4,581.4	2,997.1	(1,584.3)	65.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	72,477.4	52,666.9	(19,810.5)	72.7
210807	Газрын төлбөр	21,743.8	15,234.3	(6,509.5)	70.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,991,632.4	3,406,291.9	(585,340.5)	85.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,700,838.1	3,251,148.7	(449,689.4)	87.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	290,794.3	155,143.2	(135,651.1)	53.4
212	ТАТААС	4,919,182.9	4,910,882.9	(8,300.0)	99.8
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	4,693,100.0	4,684,800.0	(8,300.0)	99.8
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	4,693,100.0	4,684,800.0	(8,300.0)	99.8
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	226,082.9	226,082.9	-	100.0

212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	226,082.9	226,082.9	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,241,152.0	3,807,996.2	(433,155.8)	89.8
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	51,719.0	50,000.0	(1,719.0)	96.7
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	51,719.0	50,000.0	(1,719.0)	96.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,189,433.0	3,757,996.2	(431,436.8)	89.7
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,295,473.5	2,191,268.5	(104,205.1)	95.5
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	190,661.1	170,335.5	(20,325.6)	89.3
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	129,830.0	129,830.0	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	706,465.2	660,734.4	(45,730.8)	93.5
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	315,137.6	183,125.2	(132,012.4)	58.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	551,865.6	422,702.7	(129,162.9)	76.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	54,345,427.5	40,166,754.3	(14,178,673.2)	73.9
221001	Их засвар	623,492.2	38,976.8	(584,515.4)	6.3
223001	Бусад хөрөнгө	53,721,935.3	40,127,777.4	(13,594,157.9)	74.7
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	2,821,339.3	2,579,501.5	(241,837.8)	91.4
230001	Эргэж төлөгдөх зээл	2,821,339.3	2,579,501.5	(241,837.8)	91.4
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(5,699,302.0)	(5,699,302.0)	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	33,913,177.6		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	28,213,875.6		

Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны нэгдсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мян.төг/

Дансны код	Дансны нэр, төрөл	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,194,164.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,194,164.6
122	Тусламжийн орлого	2,194,164.6
1221	Хандив тусламж /дотоод/	2,194,164.6
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,194,164.6
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	88,132.6
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,214.5
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,467,897.6
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	602,919.9
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,194,164.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,145,364.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,987,268.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	180,394.3
210101	Үндсэн цалин	102,781.4
210102	Нэмэгдэл	11,768.5
210104	Урамшуулал	6,507.0
210105	Гэрээт ажлын хөлс	59,337.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,384.9
210201	Тэтгэврийн даатгал	4,421.2
210202	Тэтгэмжийн даатгал	479.0

210203	ҮОМШӨ-ний даатгал	269.7
210204	Ажилгүйдлийн даатгал	248.5
210205	Эрүүл мэндийн даатгал	966.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,462.0
210301	Гэрэл, цахилгаан	2,562.0
210302	Түлш, халаалт	2,900.0
2104	Хангамж, бараа материалын зардал	152,922.6
210401	Бичиг хэрэг	6,872.4
210402	Тээвэр, шатахуун	102,977.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,018.1
210404	Ном, хэвлэл	1,750.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,695.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	34,609.5
2105	Нормативт зардал	96,922.1
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,402.5
210502	Хоол, хүнс	90,411.6
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,108.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	128,273.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	24,749.8
210602	Тавилга	11,000.0
210604	Урсгал засвар	92,524.1
2107	Томилолт, зочны зардал	3,789.5
210702	Дотоод албан томилолт	3,789.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	804,084.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	801,756.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,800.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	528.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	609,035.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	556,455.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	52,580.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	158,096.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	158,096.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,510.7
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	104,948.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	50,636.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	48,800.0
2200	Дотоод эх үүсвэрээр	48,800.0
223001	Бусад хөрөнгө	48,800.0
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	